



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/169

Сүхбаатар сум

Хүүхэд хамгааллын болон гэмт хэргээс  
урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, 30 дугаар зүйлийн 30.1.1, 38 дугаар зүйлийн 38.3, 39 дүгээр зүйлийн 39.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5-9 дүгээр зүйл, Гэр бүлийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, 25 дугаар зүйлийн 25.3, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 9 дүгээр зүйлийн 9.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийн 2.2.1, 3.1.2, 3.2.2.2, 3.2.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хүүхдийг хараа хяналтгүйгээр хичээл, сургуульд нь явуулах, тоглуулах үед хүүхэд алга болох, хүүхдийг хулгайлах оролдлого, тохиолдлууд гарч байгаатай холбогдуулан Олон Улсын Гэр бүлийн өдөр, Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Хамгаалагдсан хүүхэд-Хариуцлагатай гэр бүл” аяныг аймгийн хэмжээнд 2019 оны 12 сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.


2.Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас Ерөнхий боловсролын сургуулиудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгуулсан гэрээг үр дүнтэй хэрэгжүүлэх, сургууль, цэцэрлэгийн орчимд эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй эцэг, эхчүүдийн тоог нэмэгдүүлж, хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулахыг нийт сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, сум, багийн Засаг дарга, аймгийн Цагдаагийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж болон аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж аж ахуйн нэгж, байгууллага, дэлгүүр, худалдаа, үйлчилгээний газар бүр гадна, дотно орчноо бүрэн камержуулж, аж ахуйн нэгж, байгууллага бүр дэргэдээ хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хамгаалах зорилго бүхий “Эцэг, эхийн зөвлөл”-ийг байгуулж, хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг нийт аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Бага насны хүүхдийг сургууль, цэцэрлэг, уралдаан, тэмцээн, давтлага, секц дугуйланд явуулахдаа хүргэж өгөх, тарахад нь тосож авах, анхаарал, халамж, хараа хяналтыг байнга тавьж, хүүхэд хамгааллын ажилд идэвх санаачилга гарган ажиллахыг нийт эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт уриалсугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/, аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа /А.Энхбат/, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга /П.Оюун/ нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ